СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК

Монголын МНБИ болон ТМЗН-ийн гишүүн байгууллага

“МОЛОР ОРД” ХХК

(Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)
Аудитлагдсан санхүүгийн тайлан
2020 оны 12 дугаар сарын 31

Улаанбаатар

2021 он

АГУУЛГА **ХУУДАС**

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ..... 3
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН 3-5
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН 6-7
ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН 8-9
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН 10
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН 11
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД..... 12-20
ГЭРЭЭТ АЖЛЫН ЗАХИДАЛ..... 21-22

С Э Р Э Л Т
ДӨЛ АУДИТ ХХК

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;
Цахим шуудан: altantsetseg@sdaudit.mn

2021.03.29 № СТА/21-27
танай _____ -ны №_____-т

"МОЛОР ОРД" ХХК-ний
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид "Молор Орд" ХХК-ний 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн чухал бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бид "Молор Орд" ХХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн зөв, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт тусгасан.

Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "НБЁЗОУСЗ-ын дүрэм" гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм.

Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бүр тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог.

Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоонд суурилна. Компанийн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг бид бүхэлд нь үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын ажлын хамрах хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудын талаар харилцсан.

Бусад зүйлс

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Компанийн Хувьцаа эзэмшигчийн захиалсан аудиттай холбогдуулан “Молор Орд” ХХК -ийн хувьцаа эзэмшигчид зориулан гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

“СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ” ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид /**Д.АЛТАНЦЭЦЭГ**/
Захирал, МНБ

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2021 оны 03-р сарын 29

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2019.12.31	2020.12.31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгөн хөрөнгө	249,894.0	219,208.8
Бэлэн мөнгө	200,945.4	205,979.0
Банк санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах	48,948.6	13,229.8
Зээл /цэврээр/	**1,521,113.1**	**1,642,911.5**
Нийт зээл	**1,521,113.1**	**1,642,911.5**
Хэвийн зээл	1,481,113.1	1,585,911.5
Хугацаа хэтэрсэн зээл	40,000.0	40,000.0
Чанаргүй зээл		**17,000.0**
Муу зээл		17,000.0
Бусад авлага		7,884.3
Бусад авлага		438.3
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага		7,446.0
Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага		7,446.0
Эргэлтийн хөрөнгийн нийт дүн	**1,771,007.1**	**1,870,004.6**
Үндсэн хөрөнгө	2,508.2	4,651.6
Эд хогшил	3,367.4	4,225.4
Хуримтлагдсан элэгдэл /эд хогшил/	859.2	1,093.6
Техник хэрэгсэл	2,500.0	4,313.6
Хуримтлагдсан элэгдэл / техник хэрэгсэл /	2,500.0	2,793.8
Биет бус хөрөнгө	125.5	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	**2,633.7**	**4,651.6**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**1,773,640.8**	**1,874,656.2**
Бусад өр төлбөр	8,945.0	10,708.6
Бусад өглөг	8,945.0	10,708.6
ЭМД,НДШ-ийн өглөг	152.2	263.3
ХАОАТ-ын өглөг	179.9	348.2
Орлогын албан татварын өглөг	8,612.9	10,097.1
Богино хугацаат өр төлбөрийн дүн	8,945.0	10,708.6
Нийт өр төлбөрийн дүн	8,945.0	10,708.6
Энгийн хувьцаа	1,600,000.0	1,600,000.0
Хувьцаат капиталын дүн	**1,600,000.0**	**1,600,000.0**
Бусад өмч	**164,695.8**	**263,947.6**
Хуримтлагдсан ашиг/алдагдал/	**164,695.8**	**263,947.6**
Тайлант үеийн ашиг/алдагдал/	155,090.7	99,251.7

Өмнөх үеийн ашиг/алдагдал/	9,605.1	164,695.9
Эзэмшигчдийн өмчийн дүн	**1,764,695.8**	**1,863,947.6**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	**1,773,640.8**	**1,874,656.2**

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2019.12.31	2020.12.31
Хүүгийн орлого	**189,156.9**	**210,832.4**
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	188,473.7	200,969.6
Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого		9,814.7
Харилцах дансны хүүгийн орлого	683.2	48.1
Цэвэр хүүгийн орлого	**189,156.9**	**210,832.4**
Хүүгийн бус орлого	2,733.0	3,877.4
Санхүү үйлчилгээний шимтгэл	2,733.0	3,877.4
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	2,733.0	2,075.1
Бусад үйлчилгээ		1,802.3
Хүүгийн бус зардал	**25,527.8**	**104,630.3**
Боловсон хүчний холбогдолтой зардал	**11,940.9**	**23,384.9**
Үндсэн болон нэмэгдэл цалин	10,266.4	18,727.9
Нийгмийн даатгал эрүүл мэндийн даатгалын зардал	1,649.5	2,737.0
Сургалтын зардал	25.0	1,920.0
Бусад зардал	**13,586.9**	**81,245.4**
Аудитын төлбөр мэргэжлийн үйлчилгээ	1,000.0	1,100.0
Түрээс	7,200.0	12,000.0
Ашиглалтын зардал		2,200.0
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	1,423.0	653.7
Харилцаа холбоо интернэт		264.0
Шатахуун болон тээврийн зардал	79.5	4,005.0
Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ		9,563.2
Зохицуулалтын хураамжийн зардал	2,200.0	2,200.0
Зар сурталчилгаа, маркетингийн судалгаа	240.0	3,260.0
Бичиг хэргийн зардал	801.1	5,427.6
Ариун цэврийн зардал		1,061.1
Бусад	643.3	39,510.8
ЦЭВЭР ХҮҮГИЙН БУС ОРЛОГО/ЗАРДЛЫН ДҮН	**-22,794.8**	**-100,752.9**

Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал	166,362.1	110,079.5
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ	**166,362.1**	**110,079.5**
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	**5,960.9**	
Алданги	5,960.9	
Ердийн үйл ажиллагааны ашиг/алдагдал	**172,323.0**	**110,079.5**
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	**172,323.0**	**110,079.5**
Орлогын татварын зардал	17,232.3	10,827.7
ЦЭВЭР АШИГ	**155,090.7**	**99,251.8**

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг	Дүн
2019 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	**1,200,000.0**	**109,605.1**	**1,309,605.1**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			
Залруулсан үлдэгдэл	1,200,000.0	109,605.1	1,309,605.1
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал		155,090.7	155,090.7
Ногдол ашиг		100,000.0	100,000.0
Хувьцаат капиталын өсөлт	400,000.0		400,000.0
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**1,600,000.0**	**164,695.8**	**1,764,695.8**
Залруулсан үлдэгдэл	**1,600,000.0**	**164,695.8**	**1,764,695.8**
Тайлант үеийн цэвэр ашиг, (алдагдал)		99,251.8	99,251.8
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**1,600,000.0**	**263,947.6**	**1,863,947.6**

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2019.12.31	2020.12.31
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	**-40,499.9**	
Үйл ажиллаагааны мөнгөн орлого	**465,873.4**	
Зээлийн хүүгийн орлого	193,523.6	
Үнэт цаасны хүүгийн орлого	270,226.6	
Харилцах дансны хүүгийн орлого	48.1	
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	2,075.1	
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**506,373.3**	
Ажилтануудад олгосон нөхөн олговор, тэтгэмж	17,885.0	
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	1,550.0	
Албан томилолт сургалтын зардал	1,920.0	
Шатахуун холбоо, интернэт сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	4,269.0	
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	5,427.2	
Татвар, даатгалын төлсөн мөнгө	9,291.8	
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	3,260.0	
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	1,100.0	
Зохицуулалтын үйлчилгээний хураамжи д төлсөн мөнгө	2,200.0	
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	392,025.0	
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	67,445.3	
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	**9,814.7**	
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	**9,814.7**	
Бусад	9,814.7	
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-30,685.2	
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	**249,894.0**	
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	**219,208.8**	

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

Санхүүгийн тайлангийн тодруулга

4. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2019	2020
Касс дахь мөнгө	200,945.4	205,979.0
Банкин дахь мөнгө	48,948.6	13,229.7
Нийт дүн	**249,894.0**	**219,208.7**

Банкин дахь төгрөгийн харилцах дансанд жилийн 7.2% хүртэл, гадаад валютын харилцах дансанд жилийн 1.2%-ийн хүү боддог. 2020 оны жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 30,685 мянган төгрөг буюу 12%-иар буурсан үзүүлэлттэй байна.

5. Зээл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2019	2020
Хэвийн зээл	1,481,113.1	1,585,911.5
Хугацаа хэтэрсэн зээл	40,000.0	40,000.0
Чанаргүй зээл		17,000.0
Нийт дүн	**1,521,113.1**	**1,642,911.5**

6. Бусад авлага

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2019	2020
Авлага		438.3
Нийт дүн		**438.3**

7. Хуримтлүүлж тооцсон хүүгийн авлага

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2019	2020
Хүүгийн авлага тооцов		7,446.0
Нийт дүн		**7,446.0**

8. Үндсэн хөрөнгө

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2019	2020
Тавилга эд хогшил	3,367.4	1,093.6
Компьютер, бусад хэрэгсэл	2,500.0	2,793.8
Нийт дүн	**5,867.4**	**3,887.4**

НББОУС 16-д зааснаар Үндсэн хөрөнгийн солилцоо болон буцалтгүй тусламжаар авсан хөрөнгийг бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Бусад тохиолдолд анхны өртгөөр нь бүртгэнэ. Компани үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцдог.

9. Биет бус хөрөнгө

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2019	2020
Программ хангамж	125.5	
Нийт дүн	**125.5**	

10. Орлого

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2019	2020
Хүүгийн орлого	188,473.7	
Нийт дүн	**188,473.7**	

11. Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилт

Бүртгэлийн дүнтэйгээ ойролцоо бодит үнэ цэнэтэй санхүүгийн хэрэглүүр

Компанийн 2020 оны 12-р сарын 31-ний байдлаарх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүд нь бүгд нэг жилээс бага дуусгавар хугацаатай, богино хугацаатай байдаг.

12. Капиталын удирдлага

Компанийн хөрөнгийн удирдлагын үндсэн зорилго нь өөрийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих, өр төлбөрөө барагдуулах ба хувь нийлүүлэгчдийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

Хөрөнгийн бүтцийг хэвийн хадгалах эсвэл өөрчлөхийн тулд Компани хувьцаа эзэмшигчдэд төлөх ногдол ашгийн хэмжээг тохируулан тогтоох, хувьцаагаа хувьцаа эзэмшигчдэд буцааж өгөх эсвэл шинэ хувьцаа гаргах зэрэг арга замыг ашиглах боломжтой.

Компанийн зорилт, бодлого болон үйл ажиллагаанд 2019 болон 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар өөрчлөлт ороогүй болно.